



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 05 сарын 18 өдөр

Дугаар 0/275

Улаанбаатар хот

Тоног төхөөрөмжийн ашиглалтыг
зогсоох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 13 дугаар зүйлийн 13.2, Иргэний нисэхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Ховд аймгийн Булган сумын нисэх буудлын ашиглалтын хугацаа дууссан 89112, 89109 үйлдвэрийн дугаартай ПАР-10 маркийн чиглүүлэх радио нэвтрүүлэгч, 58037, 59049 үйлдвэрийн дугаартай Е615 маркийн маркерийн радио дохиологч станцуудыг 2018 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн UTC 00:00 цагт ашиглалтыг зогсоон, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас хасаж, татан буулгасугай.

2. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас хасагдсан тоног төхөөрөмжүүдийг татан буулгах, дагалдах сэлбэгийн хамт актлуулах, агаарын навигацийн үйлчилгээний тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах, техникийн бэлэн байдлыг ханган ажиллахыг Техник хангалт, навигацийн үйлчилгээний алба /Д.Баяртогтох/, зарлан мэдээлэх ажлыг зохион байгуулахыг Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба /П.Ариунгэрэл/-нд тус тус үүрэг болгосугай.

3. Тоног төхөөрөмж татан буулгахтай холбогдон гарах зардлыг санхүүжүүлэхийг Санхүү, эдийн засгийн хэлтэс /Ч.Нямсүрэн/-т зөвшөөрсүгэй.

4. Тоног төхөөрөмжийн ашиглалтанд өөрчлөлт орж байгаатай холбоотойгоор үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүйгээр зохион байгуулж, агаарын навигацийн үйлчилгээний аюулгүй ажиллагааг ханган тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтэс /Ё.Эрдэнэбат/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН